

Монголын нууц товчоон дахь
“Хоч нэр”-ийн тухай

Э.Жигмэддорж (МУИС)

Түүхийн сурвалж бичгүүд, аман мэдээ, домог зэргээс үзвэл монголчуудын дунд эрт дээр үеэс ямарваа нэгэн хүнд хоч тогтоон өгөх, хочлон нэрлэх явдал байсан нь лавтай бөгөөд энэ талаар тодруулан үзэж болохуйц гол зохиол нь “Монголын нууц товчоо” юм.

Судлаачид “Нууц товчоон”-нд таван зуу гаруй бодит түүхэн хүн болон домгийн зарим баатрын нэрс байгааг судлан тогтоосон байна¹. Тэдгээр 500 гаруй нэрийн цөөнгүй хувийг хүний хоч нэр эзэлж байгаа төдийгүй нэр хочийн тайлбар ч олонтаа тохиолдох бөгөөд энэхүү асуудал нь сонирхууштай, судлууштай сэдэв билээ.

Учир иймд бид тус зохиол дахь хүний хоч нэр, тэдгээрийн утга, онцлогын талаарх зарим зүйлийг бага ч болов хөндөхийг зорьсон амуй.

Персийн нэрт түүхч Рашид-ад-дин зохиолдоо “Хүн бүр өөрийн хочинд (цолонд) тохирсон зэрэг дэвийг мэдсэн байдаг. Ингэхлээр нэг хуралд оролцож байгаа зуун хүнийг хочоор нь хэн ямар тушаалтай, хаана суух ёстойг нь тодорхой мэддэг...”² хэмээсэн нь XII, XIII зууны Монголчуудын дунд аливаа хүнд хоч тогтоон өгөх явдал ихэд түгээмэл хэрэглэгдэж байсны нэгэн гэрч гэлтэй. Нөгөөтэйгүүр “Нууц товчоон”-ны баримтаас бүр VIII зууны үед ч хочоороо алдаршин дуудагдах явдал байсныг мэдэж болно.³

Монголын нууц товчоон дахь хүний хоч нэр агуулгын хувьд дараах хандлагатай байна. Үүнд; 1. Харилхасан буюу шоглосон, 2. Өхөөрдсөн буюу энхрийлсэн, 3. Хүндэтгэсэн буюу алдаршуулсан өнгө аястай зэрэг болой⁴.

1-р хэв шинжийн тухай сурвалжид “*žadirgeu-ü kögön bülege kegen žažiradai nereidbe.*”(§ 40), “*Barižü abugsan eme bülege kegen tere kögön-i Baýaridai nereidbe.*”(§41), “*Tere Qabiči-Baýatur-un eke-jin inže iregsen-i Bodončar tatažu bülege.Negen kögön törebe.žegürdei neretü bülege*”⁵ (§43) хэмээсэн нь эртний Монгол хүний хоч нэр болоод түүнийг хэрхэн өгч байсан тухай чухал мэдээ юм.

Дээр иш татсан баримтаас үзэхүл сурвалжийн энэ хэсэг дэх хүний хоч нэрийн зүйлд “шоглосон” (доромжилсон) өнгө аяс зонхилж байгааг тэмдэглэх учиртай.

¹ О.Намнандорж. Монголын нууц товчооны түүхт нэрс. УБ., 1996. 1, 3-р тал.

² Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р дэвтэр. УБ., 1994. 88-р тал.

³ Бүртэ-Чинуа 758 онд төрсөн (Х.Пэрлээ. Монголын түүхийн урьд мэдэгдээгүй зарим он цагийн мэдээ. ЭШӨ. Боть I, УБ., 2001. т.151.) хэмээн үзвэл энэ нь зарим талаар батлагдаж байна.

⁴ Э.Жигмэддорж. Монгол хүний хоч нэрийн түүхэн уламжлал. МУИС-НУФ. Оюутны эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2002. 134-р тал.

⁵ Монголын нууц товчоо. УБ., 1990. (Б.Сумъяабаатрын галигаас иш татав).

Сурвалжид дурьдагдсан хоч нэр нь уг хүний гадаад төрх байдал, зүс царай, зан авир, эрхлэх ажил, ямар нэг юмтай зүйрлэсэн, өвөг дээдсээс уламжлан ирсэн зэрэг онцлог ялгавартай ажээ. Эдгээрийг дор тодруулан авч үзвээс;

Тухайн хүний гадаад төрх байдлаар нь:

Мэнгээлик (§68) – Энэ нэрийг Гаадамба олон мэнгэт гэсэн монгол үгээр илэрсэн хоч нэр гэсэн бол Элдэндай Ардажав “Мэнглик” гэгч Турк хэлний Мэнгэтэй хүн гэсэн үг хэмээн тайлбарлав⁶, **Таргудай-Хирилтуг** (§72) - Үүний Таргудай гэдэг нь хэтэрхий тарган, морь унаж чаддаггүй, Хирилтуг нь Рашид-ад-дины тэмдэглэснээр Харамч, Хирлэгч гэсэн утгатай бөгөөд Тэр нэгэнт ийм чанартай нэгэн байсан гэдэг⁷, **Хонхотан** (§47) – мөн тэрбээр “Том хамарт” гэж тайлбарласнаас үзвэл Хонхор нүдтэй, том хамартай хүний удмынхан бололтой⁸, **Елюй-Цу цай** – Түүнийг тэр үед (XIII зуун Э.Ж.) “Урт сахалт” хэмээн хочлон дууддаг байжээ⁹, **Доголадай** (§46) – Уг нэрийг Пеллио “Доголон” гэсэн утгатай гэж тайлбарласан бол Гаадамба “Доголад овгийн хүн” хэмээжээ¹⁰, **Өкин (Охин) Бархаг** (§48) – Тэрээр туйлын үзэсгэлэнтэй, маш цэвэрхэн царайтай байсан учир харсан бүхэн түүний гоо сайхныг шагшин магтдаг байжээ. Иймээс охин хэмээх болсон¹¹ бол **Овор хэмжээ, биеийн онцлогт нь таацуулан Баруладай** (§46) – Цэнд гүн гар бичмэлдээ “Их биет идээ барах бөлгөө. Барулас овогтон болов¹²” гэжээ, **Их Барула** (46§), **Өчүүхэн Барула** (46§) **Их Цэрэн** (51§) гэх мэтээр нэрлэсэн тохиолдол олонтаа үзэгдэнэ.

Хүний зүс царай, зан авиртай нь холбоотойгоор:

Сорхон шар (§58), **Харгил шар** (§218), **Цагаан гоо** (§210) **Уужим буурал** (§2), **Дайр үсүн** (§102)– Энэ нь “цайвар үст” гэсэн хоч¹³ нэр бөгөөд тэр хүн толгойдоо онго цагаан үстэй учир тийнхүү нэрлэгдэж байсан бололтой (Э.Ж.), **Байшинхор догшин** (§47), **Дөрбэй догшин** (§240), **Мөчи бүдүүн** (§120) – Хэниш абугай хятад үсгийн галигаас “Мочи Бэдүүн” гэж сэргээн хүний нэр гээд “Модочи (Мужаан)”, Дамдинсүрэн, Баяр, Мансан нар. “Мөч бүдүүн” гэсэн хоч, Гаадамба энэ хүн “Мужи (зөрүүд)”, “Битэгүн (дуугүй битүү)” хэмээх хоч нэрээр алдаршсан¹⁴ хэмээн тус тус тайлбарлажээ.

Ачиг ширүн (§170) – энэ нэрийн утгыг Элдэндай Ардаажав Түрэг хэлний “Ачиг (уур хилэн)”, “Ширүн (ширүүн)” хэмээн тайлбарласан бол Гаадамба “Ачианы шор” гэсэн хочтой хүн байсан гэсэн нь сонирхолтой бөгөөд харин, цаашид нягтлууштай мэт санагдна, **Бодончар мунхаг** (§19) – “...Мунхаг хэмээх дагавар нь **Мухар** буюу эрх мэдэлгүй гэсэн утгатай нэмэлт хоч буюу доромж нэр ба хожим боржигон овгийг толгойлох болсон үеэс нь орхигджээ¹⁵”, **Наяа** – Түүнийг багад нь “Жусур” Наяа гэдэг байв. “Жусур” гэдэг нь “Зусурч”, “Ичгүүргүй”, “Бялдууч” гэсэн утгатай¹⁶, **Ноёгидай** (§46) – “Qačiin-(n)u kögön Nojagidai neretei bülege.Nojan šig aburitu Nojakin oboytan boluba”, **Адиргадай** (§46) – “Qačiyun-(n)u kögön Adarkidai neretü bülege. Aqa degü žayura adaluyči tula Adargin oboytan boluba”¹⁷ хэмээжээ.

⁶ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. 258 –р тал.

⁷ Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р дэвтэр. УБ., 1994. 130-р тал.

⁸ Ж. Өлзий. Төв азийн эртний овог аймгууд ба монгол хаадын үе уламжилсан товч түүх. УБ., 2002. 86-р тал.

⁹ Э.Жигмэддорж. Монгол хүний хоч нэрийн түүхэн уламжлал. МУИС-НУФ. Оюутны эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2002. 136-р тал.

¹⁰ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. 242-р тал.

¹¹ Рашид-ад-дин. Судрын чуулган. Боть I, УБ., 2002. 182-р тал.

¹² Цэнд гүн ба Монголын нууц товчоо. УБ., 1996. 82-р тал.

¹³ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. 229-р тал.

¹⁴ Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. 310-р тал.

¹⁵ А. Энхбат. Бодончар мунхаг нэрийн тухайд. Түүх №2. МУИС-ийн ЭШБ. УБ., 2003. 21-р тал.

¹⁶ Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р дэвтэр. УБ., 1994. 137-р тал.

¹⁷ Монголын нууц товчоо. УБ., 1990 (Б.Сумъяабаатрын галиг).

Эрхлэх ажил буюу эр зориг, ид хавийг үндэс болгон;

Житгүл бөх (§) – Хичээнгүй нөр гэсэн утгатай монгол үг¹⁸, **Бүри буха** (§56) **Жали буха** (§58), **Чилэгэр бөх** (§103), **Дай төмөр** (§177), **Буха төмөр** (§177), **Ашиг төмөр** (§186) гэх зэргээр хочилон нэрлэж байсан аж.

Хоч нэрийн дотор ямар нэгэн юмтай зүйрлэж, адилтган нэрлэсэн тохиолдол цөөнгүй үзэгдэж байна. Үүнд; **Шар нохой** (§21) - Шар нохойгоор адилтган өгүүлсэн цэгээн шар хүн бол дээд язгуурын гэрлээр бэлгэдэн үзүүлсэн домгийн сэтгэлгээний арга дүрслэл мөн¹⁹, **Убчигтай хүрэн баатар** (§160) – Убчигтай гэдэг үг энэ нутагт (Монгол Э.Ж.) ургадаг улаан жимсний нэр бөгөөд энгэсэгний оронд эмэгтэйчүүд нүүрэндээ түрхэх бөлгөө. Тэр баатарын нүүр төрлөхийн улаан учир энэ жимстэй зүйрлэн уул нэрээр нэрлэжүүхүй²⁰, **Мэгүжин сүүлт** (§132) – Татаарын энэхүү ноёны нэрийн утгыг Д.Энхбат “Гахай сүүлт” хэмээн тайлбарласан буй, **Зэв** – Нууц товчоонд “...aman çayan qula-ji min-u qarbuysan-u tula žebe nereidöü. Dergede min-u jaby kegen žarlig bolba (§147)” гэсэн нь зэв лугаа хурц эрэмгий, нугарашгүй дайнч шинж чанарыг бэлгэдсэн утгатай бололтой²¹.

Сурвалжаас үзвэл хоч нэр нь тухайн нэг овог, бүлэг хүмүүсийн өөрсдийг таниулах, түүгээрч барахгүй зарим үед бахархал, алдаршсан нэр болдог байж. Жишээ нь: **Адирган** (§46), **Жүрхин** (§139) – Тэдгээр хүмүүс ууртан, цөстөн, омогтон тул Жүрхин гэгдсэн ёс тийм бөлгөө, **Хэрэйд** (§170) – Эрт цагт долоон хүүтэй нэгэн хаан байсан гэдэг. Түүний хөвгүүд нь цөм бараан царайтай байжээ. Хэрэйд гэсний учир тэр буюу²², **Барлас** (§46) – “Qačula-jin kögün idegen baruy tula jeke Barula, Öcügen-Barula nereidöü Barulas oboytan boluba”²³, **Одүүд** (§202) – Одой буюу огтор хүмүүс байсан учир тэр нь овгийн нэр болсон бизээ (Э.Ж.), **Манан тудан** (§45) – Уг нэрийг Гүн Гомбожав зохиолдоо “Маха тудан” хэмээн бичээд түүний хатнаас төрсөн “махлаг” долоон хөвгүүн гэжээ²⁴. Тэрбээр долоон хөвгүүний “махлаг” гэсэн нь тэднийг эцгээр нь төлөөлүүлэн (адилтган) хэлсэн хэрэг бололтой. Эцэг Тудан нь том биетэй, махлаг хүн байснаас хөвгүүдийг нь тийнхүү нэрлэсэн байж болох талтай.

Ер нь одоо ч Монголчуудын дунд нэгэн овнийнхон, бүлэг хамаатан садан хүмүүсийг хочилон нэрлэх явдал цөөнгүй тохилддог. Жишээлбэл; Сарлагтынхан, улаан малгайт²⁵ гэх мэт.

Овог аймгийн домгийн шүтээн - тотем, түүний үүсгэгч эзэн тэргүүн эсхүл тэдний түүхэнд болсон онцгой үйл явдал зэрэг нь хүний хоч нэр үүсэх бас нэгэн уг сурвалж болдог байжээ. Энд тэмдэглүүштэй нь зарим үед хүний нэр, алдар улмаар тухайн овог, бүлэг хүмүүсийн ерөнхий нэрийдэл болж олонд түгэн дэлгэрч байсныг зохиолын 46-р зүйлд “Qarandai-jin kögüd будаѳан qudqulaqu eki terigü ügegün tula Badaѳad oboytan tede boluba”²⁶ хэмээснээс мэдэж болно.

Эртний Монголчуудын дунд аливаа хүнийг бага байхад нь энхрийлэн буюу өхөөрдөн өгсөн нэр нь тэр хүний жинхэнэ нэр болон үлдэх явдал байжээ. **Хоричар мэргэн** (§2) – Хори овгийн бяцхан толгойлогч гэсэн утгатай²⁷, **Зүчи** (§165) – Гэнэт зочмог төрсөн учир хүүхдийг Жочи нэрлэжээ²⁸, **Шиху хутуг** (§135) – сурвалжид “Сайн хүний хөвгүүн биз,

¹⁸ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. 239-р тал.

¹⁹ Цэрэнсодном, Д. МНТ-ны орчуулгын тайлбар. Бээжин, 1993. 284-р тал.

²⁰ Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р дэвтэр. УБ., 1994. 105-р тал.

²¹ Э.Жигмэддорж. Монгол хүний хоч нэрийн түүхэн уламжлал. МУИС-НУФ. Оюутны эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2002. 136-р тал.

²² Монголын түүхийн дээж бичиг. 2-р дэвтэр. УБ., 1992. 5-р тал.

²³ Монголын нууц товчоо. УБ., 1990. (Б.Сумъяабаатрын галиг).

²⁴ Гүн Гомбожав. Чингис эзний алтан ургийн түүх гангын урсгал нэрт бичиг оршив” УБ., 1992. 5-р тал.

²⁵ Булган аймгийн Хишиг-Өндөр, Завхан аймгийн Отгон зэрэг суманд ийнхүү нэрлэх тохиолдол байна.

²⁶ Монголын нууц товчоо. УБ., 1990. (Б.Сумъяабаатрын галиг).

²⁷ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. УБ., 1990. 223-р тал.

²⁸ Рашид-ад-дин. Судрын чуулган. 1-р дэвтэр. УБ., 1994. 53-р тал.

язгуур сайт хүний ураг биз, Шихи гэдэг нэр өгч асрав²⁹ гэсэн нь түүнийг гаднаас нь дүгнэсэн мэт боловч чухамдаа оюун ухаан, билэг чадварыг үндэс болгон нэрлэсэн болой. Учир юун гэвэл, тэрбээр хожимоо Монголын олон ноёдын дотроос шалгаран гарч “Улсын их заргач” болсон нь тохиолдлын хэрэг байсангүй нь лавтай. Зарим судлаачид “Шиги” – гэдэг нь чигчий хуруу мэт бяцхан, “хуту” нь хурц ухаан гэсэн үг³⁰ хэмээн тайлбарласанд тал өгч болох юм.

Ж.Сэржээ “Монгол хүний нэр” бүтээлдээ “...Нэрийг хэр зэрэг ёс төртэй өгөв гэдэг нь гол бус, харин хэр зэрэг утга агуулагтай сайхан нэр өгөв гэдэг нь эрхэм юм”³¹ гэжээ. Үнэхээр ч нэр нь тухайн хүнийхээ онцлог, бусдаас ялгарах шинж байдлыг илэрхийлэхийн зэрэгцээ аз жаргалтай, элбэг дэлбэг, энх тунх байхыг бэлгэдэн ерөөсөн (алдаршуулсан) байдаг амуу.

Сурвалжийн мэдээ болоод судлаачдын санал дүгнэлтийг хооронд нь нягтлан үзэхэд, “Нууц товчоон” дахь хүний хоч нэрийн дотор **алдаршуулж, өргөмжилсөн нэр цөөнгүй аж.** Үүнд; **Дува сохор** (§3) – Ё. Баяр “Энэ хүн сохор биш, энэ хүний ухааны мэлмий нээгдсэнийг хэлсэн бололтой”³² гэжээ, **Боржигдай мэргэн** (§3), **Торголжин баян** (§3), **Боргочин гуа** (§3), **Хорилардай мэргэн** (§8), **Хүгсү сабраг баатар** (§162), **Хуйлдар сэцэн** (§171), **Буха төмөр** (§177) зэрэг олон нэр буй бөгөөд эдгээр нь ерөнхийдөө тухайн нэг хүнийг дээдлэх хүндэтгэх чанартай хэрэглэгдэж байжээ.

Ийнхүү тухайн хүн нэрээрээ бус хочоороо алдаршин дуудагдах явдал өнөө үед ч уламжлагдан ирснийг дашрамд тэмдэглэе.

Дээр дурьдсан бүгдээс товч дүгнэхүл;

1. Зохиолын эхний хэсэгт хүний хоч нэр, тэдгээрийн утга, тайлал, хүний нэрнээс овгийн нэрийдэл үүссэн тухай баримт олонтаа дурьдагдаж буй нь Монголчуудын дунд аливаа хүнийг хочилон нэрлэх ядал эртнээс нааш уламжлан ирсний илэрхийлэл бололтой.

2. Сурвалжаас үзэхэд эрт үеийн монгол хүний хоч нэр нь тэрхүү хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, гадаад төрх, зан чанар, ид хавийг, харин овог аймгийн хувьдаа тэдний гарал үүсэл, бусдаас ялгарах онцлог зэргийг тусган харуулдаг байжээ хэмээн үзэж болохоор...

3. Нөгөөтэйгүүр тэдгээр нэрэнд тухайн үеийн хүмүүсийн аж амьдрал болоод шүтлэг, итгэл бишрэл, үнэлэмж, тэр цагийн хүмүүс чухам юуг эрхэмлэн үздэг байсан зэрэг нь ямарваа нэгэн хэмжээгээр тусгалаа олжээ.

4. Хоч нэрийн дийлэнх нь Монгол хэлний үгээс бүтсэн байх агаад тэдгээр нь тус бүрдээ тодорхой утга агуулгатай, ихэвчлэн тухайн хүнийг бусдаас ялгах шинж чанартай хэрэглэгдэж байжээ.

5. Монголчуудын нэр хоч өгч байгаа шоглох, өхөөрдөх гэх мэт явдал нь бүр эрт дээр үеэс уламжлал, залгамж холбоотой бөгөөд бусад ард түмний нэр хоч өгөх нийтлэг зарчимтай тохирч байна.³³

6. Монгол хүний хоч нэрийн утгыг ажиглавал гадаад төрх байдал, өнгө зүс, зан чанарыг заасан үг (хэллэг)-ээр нэр үүсэх явдал түгээмэл тохиолдож байгаа нь нүүдэлчдийн ахуй соёлын онцлогоос үүдэлтэй аж.

7. Эртний Монгол хүний нэрийн бүтэцээс харахад оноосон нэрийн хойно бичигдсэн тодотгол нь ихэвчлэн хоч байсан бол энэ нь түүхэн урт удаан хугацааны явцад хувирч өөрчлөгдсөөр иржээ. Тухайлбал; ХХ зууны үед тухайн нэг хүнийг “Боохой” Данзан, “Босоо”

²⁹ Монголын нууц товчоо (ред – Ц. Дамдинсүрэн). УБ., 1990.

³⁰ Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ., 1991. 61-р тал.

³¹ Ж.Сэржээ. Монгол хүний нэр. УБ., 1992.

³² Ё.Баяр. Чингисийн үзэл ертөнцийн язгууртай болохын учир. УБ., 1998. 15-р тал.

³³ Э.Жигмэддорж. Монгол хүний хоч нэрийн түүхэн уламжлал. МУИС-НУФ. Оюутны эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2002. 136-р тал.

Шагдар, "Буур" Жамъян, "Пионер" Бадам (эдгээр нь ихэвчлэн өргөмж, хүндэтгэлийн чанартай хэрэглэгдэг байжээ) хэмээн хочлон нэрлэх явдал ихэд түгэн дэлгэрчээ.³⁴

Сурвалжид буй хүний хоч нэрийн дотор язгуур Монголоор хязгаарлагдахгүй Түрэг зэрэг хэлний зарим үг хэллэг үзэгдэж байгаа нь сонирхолтой бөгөөд тэдгээрийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай ажээ.

About Nicknames in secret history of Mongolia

Summary

by E.Jigmeddorj

The contest of nicknames and their meanings and person's name was arisen from clan's names in the secret history is proved the traditional giving nicknames among Mongolian people from ancient time.

Ancient Mongolian person's names and clan's names were meant his position of social, character, appearance and origin, territory, nomadic way of life and special feature from others.

³⁴ Саруул. И., Жигмэддорж, Э. Монгол бөхийн хоч нэрийн тухай, Аста Mongolica. Vol 2(208) 2003.158-р тал.

